

**ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ
“ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ
ХАНГАХ ХӨТӨЛБӨР”-ИЙН БИЕЛЭЛТ**

/2024 оны жилийн эцсийн байдлаар/

№	Үйл ажиллагаа	Хэрэгжилт	Хэрэгжилт хувь
1. Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх чиглэлээр			
1	Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт	Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн А/74 дугаар тушаалаар Яамны албан хаагчдын “Сургалтын хөтөлбөр”-ийг шинэчлэн батлуулсан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор жил бүр сургалтын төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн даргаар батлуулан хэрэгжилтийг зохион байгуулж байна. 2024 оны сургалтын төлөвлөгөөний дагуу нийт 23 төрлийн сургалтад давхардсан тоогоор 303 албан хаагч хамрагдсан. Үүнээс мэргэшүүлэх сургалтад 97, бусад сургалтад 195, гадаадын богино хугацааны сургалтад 39, Гадаадын их дээд сургуулийн магистрын тэтгэлэгт 3 албан хаагч суралцсан байна. Тухайлбал: -Удирдлагын академийн сургалтад нийт 72 албан хаагч сургалтад хамрагдсан. Үүнд: Тэргүүн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 1, Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 5, Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 11, Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалт 4, Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалт 1, Төрийн албан анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх сургалтад 5, Зорилтод сургалт болох Жендерийн мэдрэмжтэй төсөвлөлт сэдэвт сургалтад 3, Амжилт бол сонголт сэдэвт сургалтад 1, Үр дүнд суурилсан гүйцэтгэлийн тайлан сэдэвт сургалтад 2, Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, үнэлэх аргачлал сэдэвт сургалтад 2, Кибер аюулгүй байдал сэдэвт сургалтад 1, Төсвийн хөрөнгө оруулалтын шинжилгээ сэдэвт сургалтад 2, Мега хотын засаглалын шинэчлэл сэдэвт сургалтад 8, "Шалгуур үзүүлэлт, түүнийг хэмжих аргачлал боловсруулах нь" 4, "Монгол Улсын хөгжлийн бодлого-Үр дүнд суурилсан төлөвлөлт, гүйцэтгэл" 15, "Монгол Улсын тогтвортой хөгжлийг хэрэгжүүлэх үр дүнтэй засаглал" сургалтад 2, "Төрийн захиргааны гүйцэтгэлийн удирдлага" сургалтад 3, "Төрийн албан удирдах албан тушаалтны ур чадварыг хөгжүүлэх нь" сургалтад 3 албан хаагч хамрагдсан. Худалдан авах ажиллагааны газартай хамтран зохион байгуулсан “Худалдан авах ажиллагааны мэргэшлийн сургалт”-д 68,	100

		"Зам, тээврийн салбарын нэгдсэн платформ 2.0" хувилбарыг хөгжүүлэх ажлын хүрээнд "Developer license" олгох сургалтад 26, Монгол бичгийн анхан шатны сургалтад 44, дунд шатны сургалтад 51 "Архив, албан хэрэг хөтлөлт" сэдэвт сургалтад 1 албан хаагчид хамрагдсан. Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг 18 удаагийн арга зүйн цахим сургалтад албан хаагчдыг хамруулсан.	
2	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт	Тайлант хугацаанд зохион байгуулагч талын зардлаар гадаадын сургалтад хамрагдсан нийт 31 албан хаагч хамрагдсанаас магистрын тэтгэлэгт сургалтад 2, богино хугацааны сургалтад 29 албан хаагч хамрагдсан байна.	100
3	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн	Удирдлагын академи болон олон улсын байгууллагуудын зохион байгуулагч талын зардлаар зохион байгуулсан сургалтад албан хаагчдыг хамруулсан. Албан хаагчдыг сургах, мэргэшүүлэх чиглэлээр сургалтын төлөвлөгөөнд туссан 4,195,000 сая төгрөгийг зарцуулсан байна.	100
2. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр			
4	Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	Монгол Улсын Засгийн газрын 2023 оны "Цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүр, түүнийг хэрэглэх төрийн байгууллагын жагсаалт, орон тооны дээд хязгаар тогтоох тухай" 212 дугаар тогтоолын дагуу төрийн үйлчилгээний 2 албан хаагчийн цалингийн итгэлцүүрийн дагуу цалинжуулж эхэлсэн. 2024 оны хагас жилийн байдлаар албан хаагчдын цалин хөлс, шагнал урамшуулал болон хоол, унааны зардалд 2,818,299,237 төгрөг зарцуулсан байна.	90
5	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх	Ажлын байрны урсгал засвар болон их засварыг өрөөнд хийж, зарим өрөө тасалгааны цонхыг шинээр сольж ажлын байрны нөхцлийг сайжруулсан. Албан үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, эд хогшил, техник хэрэгслийн хэрэгцээг судлан тогтоож, шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусгах замаар шийдвэрлэх хүрээнд Албан үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай компьютер, дагалдах хэрэгсэл, хувилагч, хэвлэгч болон тавилга эд хогшил зэргийг шинэчлэн ажиллаж байна. ЗТЯ-ны байрны гадна пасадыг шинэчлэх ажил хийгдэж байна.	70
6	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	Ажилтнуудыг эрүүл мэндийг хамгаалахад нь дэмжлэг туслалаа үзүүлэх чиглэлээр яаманд эмчийг ажиллуулж байна. Албан хаагчдын эрүүл мэндийг өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ХӨСҮТ-т хавдрын өвчлөлөөс урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан. Тайлант хугацаанд давхардсан тоогоор нийт 110 албан хаагч үзлэгт хамрагдсан.	100

		Албан хаагчдыг аливаа өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор эрүүл мэнд, спортын арга хэмжээг тогтмол зохион байгуулж, долоо хоногт нэг удаа спорт зааланд тоглох боломжоор хангаж Төмөр замын тээврийн дээд сургуультай гэрээ байгуулж ажилласан. Мөн албан хаагчдын эрүүл мэндийг хангах, хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх зорилгоор “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын ашиглаж байсан захиргааны барилгын нэг өрөөг бялдаржуулах тоног төхөөрөмж байршуулж албан хаагчдыг ажлын байртай ойрхон бялдаржуулах өрөөг 2024 оны 01 дүгээр сард ашиглалтад оруулж ажиллаж байна. ЗТЯ-ны нийт албан хаагчдын дунд 2024 оны 10 сард Биеийн тамир спортын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, эрүүл мэнд дасгал хөдөлгөөнөөр хичээллэх зорилгоор “Бид хамтдаа” уриан дор 6 төрөлт спортын арга хэмжээг амжилттай зохион байгуулсан. Зам, тээврийн салбарын харьяа байгууллагуудын дунд спортын олон төрөлтөөр тэмцээнийг 2024 ны 11 сард үе шаттайгаа зохион байгуулна.	
7	Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал	Албан хаагчдаас цэцэрлэгийн насны хүүхдийн судалгаа авсан тус судалгаанд үндэслэн, “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын ашиглаж байсан захиргааны барилгыг хүүхдийн цэцэрлэг болгон тохижуулж, 2024 оны 03 сарын сард ашиглалтад оруулсан. Цэцэрлэг бага болон ахлах 2 бүлэгтэй, 50 хүүхдийн багтаамжтай бөгөөд үйл ажиллагаа хэвийн явуулагдаж байна. Тайлант хугацаанд Албан хаагчдад нөхөх төлбөр, тэтгэвэр тэтгэмж, буцалтгүй тусламж олгох асуудлыг Төрийн албаны тухай хууль болон байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу тухай бүр шийдвэрлэх зорилгоор 30 албан хаагчид 26.8 сая төгрөгийн буцалтгүй тусламж, 3 албан хаагчид төрийн албан хаагч тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж 132.0 сая төгрөг олгосон.	70
Нийт хэрэгжилтийн дундаж үнэлгээ: 88.6%			

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ.